



ГАЗАР ЗОХИОН БАЙГУУЛАЛТ,
ГЕОДЕЗИ, ЗУРАГ ЗҮЙН ЕРӨНХИЙ ГАЗРЫН
ДАРГЫН ТУШААЛ

2026 оны 04 сарын 21 өдөр

Дугаар А/134

Улаанбаатар хот

Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн салбарын жендэрийн эрх тэгш байдлыг хангах 2026 оны төлөвлөгөө батлах тухай

Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4 дэх хэсэг, Засгийн газрын 2026 оны 03 дугаар сарын 11-ний өдрийн “Ерөнхий төлөвлөгөө батлах тухай” 73 дугаар тогтоолын хавсралт “Нэгдсэн Үндэстний Байгууллагын хүний эрхийн зөвлөлөөс ирүүлсэн зөвлөмжүүдийг 2026-2030 онд хэрэгжүүлэх арга хэмжээний ерөнхий төлөвлөгөө”-г тус тус үндэслэн ТУШААХ нь:

1.“Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн салбарын жендэрийн эрх тэгш байдлыг хангах 2026 оны төлөвлөгөө”-г хавсралтаар баталсугай.

2.Батлагдсан төлөвлөгөөний дагуу харьяа байгууллагын хэмжээнд албан хаагчдын жендэрийн эрх тэгш байдлыг хангаж, хэрэгжилтийг бүтэн жилээр тайлагнаж ажиллахыг аймгуудын Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын дарга, нийслэлийн Газар зохион байгуулалтын албаны дарга нарт тус тус үүрэг болгосугай.

3.Төлөвлөгөөний хэрэгжилтийг удирдлага, зохион байгуулалтаар хангаж ажиллахыг Жендэрийн орон тооны бус дэд салбар зөвлөл (Ш.Мандахзул)-д, тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн захиргаа, удирдлагын газар (Б.Энхболд)-т даалгасугай.


ДАРГА



А.ЭНХМАНЛАЙ

1526010388

Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн ерөнхий газрын даргын 2026 оны 04 дүгээр сарын 21-ны өдрийн АМЗ дугаар тушаалын хавсралт



ГАЗАР ЗОХИОН БАЙГУУЛАЛТ, ГЕОДЕЗИ, ЗУРАГ ЗҮЙН САЛБАРЫН ЖЕНДЭРИЙН ЭРХ ТЭГШ БАЙДЛЫГ ХАНГАХ 2026 ОНЫ ТӨЛӨВЛӨГӨӨ

| № | Хэрэгжүүлэх үйл ажиллагаа | Шалгуур үзүүлэлт | Суурь түвшин | Зорилтот түвшин | Хугацаа | Хариуцах нэгж | Хамтран ажиллах байгууллага, төлөөлөл |
|--|---|--------------------------------------|--------------|-----------------|---------|--|--|
| 1 | 2 | 4 | 5 | 6 | 7 | 8 | 9 |
| Нэг. “Жендэрийн мэдрэмжтэй ажлын байр”-ны бодлогыг хэрэгжүүлэх хүрээнд: | | | | | | | |
| 1.1 | Жендэрийн тухай ойлголт, жендэрт суурилсан хүчирхийллээс урьдчилан сэргийлэх чиглэлээр нөлөөллийн ажил зохион байгуулах; | Зохион байгуулсан арга хэмжээний тоо | - | 1 | I-IV | Жендэрийн орон тооны бус дэд салбар зөвлөл | 21 аймгийн ГХБХБГ, НГЗБА |
| 1.2 | “Ажил, амьдралын тэнцвэр”-ийг хангах ажлыг зохион байгуулах; | Арга хэмжээний тоо | - | 1 | I-IV | Төрийн захиргаа, удирдлагын газар | 21 аймгийн ГХБХБГ, НГЗБА |
| 1.3 | “Хөдөлмөрийн дотоод журам”-д холбогдох заалтуудыг тусгах; | Тусгасан заалтын тоо | - | 1 | I-IV | Төрийн захиргаа, удирдлагын газар | 21 аймгийн ГХБХБГ, НГЗБА |
| 1.4 | 0-3 настай бага насны болон хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй ажилтанд уян хатан ажлын цагаар ажиллах нөхцөл боломж бүрдүүлэх; | Арга хэмжээний хувь | 0 | 100% | I-IV | Төрийн захиргаа, удирдлагын газар | Жендэрийн орон тооны бус дэд салбар зөвлөл |
| 1.5 | Хүйсээр ангилсан статистик мэдээллийг бүрдүүлэх, салбарын хэмжээнд нэгдсэн судалгааг гаргах; | Судалгааны тоо | 1 | 1 | IV | Төрийн захиргаа, удирдлагын газар | 21 аймгийн ГХБХБГ, НГЗБА |

Хоёр.Салбарын удирдах ажилтнууд, албан хаагчдын жендэрийн талаар мэдлэг ойлголтыг нэмэгдүүлэх хүрээнд:

| | | | | | | | |
|-----|--|---|----|----------------|------|---|------------------------------|
| 2.1 | Албан хаагчдад жендэрийн мэдрэмж, түүний талаарх ойлголт, үзэл хандлагыг нэмэгдүүлэх сургалт зохион байгуулах; | Зохион байгуулсан сургалтын тоо | - | 1 | I-IV | Жендэрийн орон тооны бус дэд салбар зөвлөл | Жендэрийн үндэсний хороо |
| 2.2 | Жендэрийн үндэсний хорооны “Удирдах албан тушаалтанд зориулсан жендэрийн цахим сургалт”-д удирдах түвшний албан хаагчдыг хамруулах; | Хамруулсан удирдах түвшний албан хаагчдын тоо | - | 99 | I-IV | Төрийн захиргаа, удирдлагын газар | 21 аймгийн ГХБХБГ, НГЗБА |
| 2.3 | Жендэрийн үндэсний хорооны “Иргэд олон нийтэд зориулсан жендэрийн цахим тест”-д албан хаагчдыг хамруулах; | Хамруулсан албан хаагчдын хувь | - | 95-аас доошгүй | I-IV | Жендэрийн орон тооны бус дэд салбар зөвлөл | 21 аймгийн ГХБХБГ, НГЗБА |
| 2.4 | Шинээр томилогдсон албан хаагчдыг жендэрийн эрх тэгш байдлыг хангах, жендэрт суурилсан ялгаварлан гадуурхалт, ажлын байрны бэлгийн дарамтаас урьдчилан сэргийлэх, эрх зүйн орчны талаар сургалтад хамруулах; | Зохион байгуулсан сургалтын тоо | - | 1 | I-IV | Жендэрийн орон тооны бус дэд салбар зөвлөл, Ёс зүйн дэд хороо | Хүний эрхийн үндэсний комисс |
| 2.5 | Хүүхэд төрүүлэх, асрах чөлөө авсан ажилтны мэргэжил, мэргэшлийн ур чадварыг өрсөлдөж чадахуйц түвшинд байлгах зорилгоор олон талт сургалтад хамруулах; | Хамрагдсан албан хаагчийн тоо | - | 7 | I-IV | Төрийн захиргаа, удирдлагын газар | 21 аймгийн ГХБХБГ, НГЗБА |
| 2.6 | Эрэгтэй, эмэгтэй албан хаагчдыг гадаад улсад зохион байгуулагдах сургалтад тэгш хамруулж, чадавхжуулах; | Хамрагдсан албан хаагчийн тоо | 27 | 30 | I-IV | Жендэрийн орон тооны бус дэд салбар зөвлөл | 21 аймгийн ГХБХБГ, НГЗБА |